

Аудитын код: САГ-2018/03/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор С.Энхтуяа
Утас: 261740 Цахим хаяг: enkhtuyas@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	1
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	4
3	АУДИТЫН ТАЙЛАН	6
3.1	Оршил	6
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	7
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
3.5	Дотоод аудит.....	8
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
3.7	Шилэн дансны мэдээлэл	10
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	10
3.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	10
3.9.1	Бараа материалын талаар.....	10
3.9.2	Авлагын талаар	11
3.9.3	Орлогын талаар.....	11
3.9.4	Төсөвт зардлын талаар	11
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	12
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	12
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	12
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3.16	Аудитын үр өгөөжийн талаар	13
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	14
4.1	Бараа материалын талаар.....	15
4.2	Авлагын талаар	16
4.3	Орлогын талаар.....	17
4.4	Зардлын талаар.....	18
5	АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	19
5.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	19
5.2	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	20
5.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
5.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	22
5.5	Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
	САНХҮҮГИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ	25

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1024
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Их Хурлын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын Их Хурлын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын Их Хурлын төсвийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0425SAG13.Docx



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3–т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Улсын Их Хурлын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Улсын Их Хурлын дарга М.Энхболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд тус байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд тайлант онд авлага нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Улсын Их Хурлын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улсын Их Хурлын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс 2018 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор С.Энхтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын Их Хурлын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 14/583 тоот албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

Улсын Их Хурлын Тамгын газар Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна Үүнд:

- Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу хууль тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх;
- Улсын Их Хурлын шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлэх;
- Улсын Их Хурал нь ардчилсан зарчимд тулгуурлан үйл ажиллагааныхаа ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах;
- Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;
- Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах бодлого зэрэг болно.

Улсын Их Хурал, түүний Тамгын газар дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Улсын Их Хурал тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Улсын Их Хурлын төсвийн эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 5 арга хэмжээ төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар товчоолов. Тухайлбал:

- Нийт бие даасан 49 хууль, нэмэлт өөрчлөлт оруулах тухай 291 хууль, Олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай 12 хууль, хууль хүчингүй болсонд тооцох тухай 20 хууль, Улсын Их Хурлын 87 тогтоолыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан;
- Монгол Улсын түүхэнд анх удаа Зөвлөлдөх санал асуулга явуулж, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлгийг улс, орон нутгийн хэмжээнд хийж, ард түмний санаа бодлыг сонсох, саналыг авах ажлыг зохион байгуулснаар 21 аймаг, 53 сум, нийслэлийн 9 дүүрэгт хэлэлцүүлгийг хийж, 327.4 мянган иргэнээс давхардсан тоогоор 5.6 сая санал авч Улсын Их Хурлаас Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийг баталсан;
- Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд саналаа ирүүлсэн иргэдийн саналыг хуваарийн дагуу програмд нэгтгэн цахим мэдээллийн сан үүсгэн, хэлэлцүүлгийн талаарх 750 цаг буюу 45000 минутын дүрс бичлэг, 1100 гэрэл зураг авч, 869 хайрцаг буюу 2607 архивын нэгж бүрдүүлсэн;
- Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны явцын талаар 1082 хуудас гар тэмдэглэл хөтөлж, дууны бичлэгээс 5463 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг буулгаж, хянан нийлж, 5970 хуудас хавсралт баримт бичгийн хамт архивт шилжүүлсэн;
- Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх ажлыг анх удаа эхлүүлж "Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж"-ийг баталж, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулан тус хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам, стандарт болон орон нутгийн түвшинд хийгдэж байгаа ажлын талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл цуглуулж, мэдээллийн сан байгуулсан ;
- Улсын Их Хурлын үйл ажиллагааг олон нийтэд шуурхай түгээж, тус бүр 28 минутын 66 нэвтрүүлэг, 428 видео мэдээ бэлтгэж www.parliament.mn цахим хуудас, [youtube.com](https://www.youtube.com) телевизүүдээр дамжуулсан; [facebook.com](https://www.facebook.com) гэх зэрэг нийгмийн сүлжээнд байршуулж,

- Монгол Улсын Их Хурал, Монголын парламентын бүлгэм, Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд нийт 25, олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд нийт 11 арга хэмжээг зохион байгуулсан;
- Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмыг боловсронгуй болгох ажлын хүрээнд нийт 5 журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлсэн
- Архивын баримтын ашиглалтыг сайжруулах зорилгоор “Төрийн архивын тоо бүртгэл-мэдээллийн АМС” програмыг нэвтрүүлсэн байна.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Улсын Их Хурлын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 19 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Улсын Их Хурлын Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2016 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улсын Их Хурлын Тамгын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхэд нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Улсын Их Хурлын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг “дунд” гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим, сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа

Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитын алба нь 2016 онд 3 орон тоотойгоор байгуулагдсан. 2017 онд Дотоод аудитын алба нь 24 сэдвийн хүрээнд аудитын ажлыг

гүйцэтгэсэн ба үүний 17 нь гүйцэтгэлийн аудит, 5 нь санхүүгийн аудит, 2 нь нийцлийн аудит байна.

Энэхүү дотоод аудитаар: Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, нэгжийн үйл ажиллагаанд аудит хийж 115 зөрчлийг илрүүлсэн ба илэрсэн алдаа зөрчлийн 30.1 хувийг хууль тогтоомжийн хэрэгжилт, 26.5 хувийг дотоод ажлын үр дүнгийн үнэлгээний асуудал, 15.7 хувийг эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, 14.5 хувийг үр ашиг, үр өгөөжийг сайжруулахтай холбоотой асуудлууд тус тус эзэлж байна.

Илэрсэн алдаа зөрчлийг засуулахаар 158 заалт бүхий зөвлөмжийг холбогдох хэлтэс, албадад хүргүүлж, биелэлтэнд нь хяналт тавин ажилласан байна.

УИХ-ын төсвийн 2016 оны жилийн эцэс, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд дотоод аудитыг хэрэгжүүлж, 9 төрлийн алдаа зөрчлийг илрүүлж, 12 зөвлөмжийг өгч, нийт 162.4 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг хангуулж, 106.7 сая төгрөгийн зардлын буруу хуваарилалтыг залруулсан байна.

Дотоод аудитын алба нь байгууллагын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудад дотоод хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн алдаа зөрчил холбогдох зөвлөмжийг өгч ажилласан боловч цаашид ажлын үр дүн болон төсвийн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл, тайлагналд хэрэгжүүлэх дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Хүснэгт №1 Улсын Их Хурлын Дотоод аудитын албаны 2017 оны дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	24	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	24	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	2	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	21
		Дүн (сая.төг)	269.1
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	12
		Дүн (сая.төг)	-
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	-
		Дүн (сая.төг)	-


Эх сурвалж: Улсын Их Хурлын Тамгын газрын Дотоод аудитын алба

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Улсын Их Хурлын Тамгын газрын 5 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 34,088.9 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 32,400.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,688.0 сая төгрөгийг батласан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 6.5 хувиар буюу 2,226.1 сая төгрөгөөр хэмнэлттэй байна. Урсгал зардалд 30,200.9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 2,200.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 1,661.9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 26.1 сая төгрөгөөр хэмнэжээ.



Улсын Их Хурлын 2017 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд бичиг хэрэг, тавилга эд хогшил, багаж техник худалдан авах зардлууд 5.0-35.0 сая төгрөгөөр хэтэрч, бусад нэр төрлийн зардал 0.9-622.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Улсын Их Хурал Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэргээр 2 нэгжийн хувьд нийт 39 төрлийн мэдээлэл байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 37, хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна.

Улсын Их Хурлын Тамгын газар өөрийн www.parliament.mn цахим хуудсны шилэн данс цэсээр дамжуулан дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл /Бүтэн жилээр/
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /Бүтэн жил, Хагас жил, Улирал, Сар бүр/
3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /Тухай бүр/
4. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /Тухай бүр/
5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл /Тухай бүр/
6. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /Сар бүр/
7. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн /Тухай бүр/ зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Бараа материалын талаар

а. Тайлант онд бусад хангамжийн материалын данснаас 15.2 сая төгрөгийн тавилга эд хогшил бэлтгэсэн, бараа материалын бусад хангамжийн материал дансанд 27.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэж, тайлагнасан.

б. Тайлант онд Хэвлэх цехийн үйлдвэрлэсэн 144.2 сая төгрөгийн Төрийн мэдээлэл сэтгүүл болон бусад бэлэн бүтээгдэхүүнийг бэлнээр болон дараа тооцоогоор борлуулсан боловч шууд зардлаар бүртгэж, тайлагнасан нь тайлант оны үр дүнг бодит бусаар өсгөх эрсдэлийг бий болгосон байна.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансдад бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн холбогдох дансдад шилжүүлэн бүртгэх тухай зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.9.2 Авлагын талаар

Тайлант онд авлагыг өмнөх оны мөн үеэс 24.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тухайлбал; Төлбөртэй үйлчилгээний орлого 16.1 сая, байгууллагаас авах авлага 4.2 сая, хувь хүмүүсээс авах авлага 3.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд шинээр авлага нэмэгдүүлэхгүй байх, өмнөх оны авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.9.3 Орлогын талаар

а) Тайлант онд УИХ-ын байнгын хороод болон УИХ-ын гишүүдийн захиалгын дагуу хэвлэх цехэд үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүний 52.8 сая төгрөгийн орлогыг батлагдсан төсвөөс нь бэлэн бусаар суутган тооцсон боловч үйл ажиллагааны орлогын дансанд бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хэвлэх цехэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний бэлнээр болон суутган, дараа тооцоогоор борлуулсан борлуулалтын орлогыг бууруулах бичилт хийлгүйгээр үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

б) Тайлант онд зарцуулсан шатахууны 6.2 сая төгрөгийн зардлыг бараа материалын дансаар дамжуулан бүртгэж, орлого зарлагыг нь хяналгүйгээр шууд зардалд бичсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэснийг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Шатах тослох материалын орлого, зарлагын гүйлгээг бараа материалын дэлгэрэнгүй тайланд тусгаж, орлого, зарлагын хөдлөл өөрчлөлт болон зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.9.4 Төсөвт зардлын талаар

а) Тайлант онд Хэвлэх цехийн үйлдвэрлэсэн 38.5 мянган ширхэг буюу 17.9 сая төгрөгийн өртөгтөй Төрийн мэдээлэл сэтгүүлийг Төрийн тусгай шуудан, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц зэрэг байгууллагуудад үнэ төлбөргүй олгосон нь үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний нэгжийн өртөг өсөх, цех алдагдал хүлээх нөхцлийг бүрдүүлсэн байна;

б) Тайлант онд батлагдсан төсвийг нийт дүнгээрээ хэмнэсэн боловч зарим нэр төрлийн зардлыг 5.4-35.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал; бичиг хэргийн зардал

5.4 сая, багаж техник хэрэгсэл худалдан авах зардал 3.4 сая, тавилга эд хогшил худалдан авах зардал 35.9 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна;

в) Тайлант онд урсгал зардлын батлагдсан төсвөөс 80.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж ...", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1.Төрийн мэдээлэл сэтгүүлийг бусад байгууллагуудад зайлшгүй шаардлагаар нийлүүлэх бол өртгөөр нь тооцон олгож, бүтээгдэхүүний нэгжийн өртгийг өсгөхгүй байх, 2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийг хэтрүүлэхгүй байх зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Завсрын аудитаар авч үзэх алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Улсын Их Хурлын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,306.3 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1,306.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс нягтлан бодох бүртгэлийн 1,090.0 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдсан 197.0 сая, залруулагдаагүй 216.3 сая, нийт 413.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж хүргүүллээ.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Улсын Их Хурлын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн 3-ийг нь бүрэн хэрэгжүүлж, төслийн нэгжийн авлага, өглөгийн тооцоо нийлж баталгаажуулах тухай 1 зөвлөмжийн хэрэгжилт 80 хувь, ашиглалтын шаардлага хангаагүй программыг бүртгэлээс хасах тухай өгсөн зөвлөмжийн талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хариу ирээгүй байгаагаас шалтгаалан хэрэгжээгүй байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргав.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар


Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Улсын Их Хурлын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 33,921.7 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь буюу 339.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын Их Хурлын төсвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

САГ-2018/03/СТА-ТЭЗ



Улсын Их Хурлын төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 2 дүгээр хэсэгт үзүүлэв.

3.16 Аудитын үр өгөөжийн талаар

Улсын Их Хурлын төсвийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,090.0 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно.

4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Улсын Их Хурлын Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Улсын Их Хурлын Тамгын газрын санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

4.1 Бараа материалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

а) Тайлант онд бусад хангамжийн материалын данснаас 15.2 сая төгрөгийн тавилга, эд хогшил бэлтгэсэн, бараа материалын бусад хангамжийн материал дансанд 27.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэж, тайлагнасан.

б) Тайлант онд Хэвлэх цехийн үйлдвэрлэж, борлуулсан 144.2 сая төгрөгийн Төрийн мэдээлэл сэтгүүл болон бусад бэлэн бүтээгдэхүүнийг шууд зардлаар бүртгэн, тайлагнаж, тайлант оны үр дүнг бодит бусаар өсгөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг тус тус мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалын дансдад бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн холбогдох дансдад шилжүүлэн бүртгэх,

Бэлэн бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг холбогдох дансдад нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

1. Санхүүгийн тайлан, байгууллагын хөрөнгө буруу илэрхийлэгдэх,
2. Тайлант оны үр дүн бодит бусаар өсөх, Борлуулалтын орлого буруу илэрхийлэгдэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар өгсөн зөвлөмжтэй танилцсан болно.

4.2 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд авлагыг өмнөх оны мөн үеэс 24.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тухайлбал: Төлбөртэй үйлчилгээний орлого 16.1 сая, байгууллагаас авах авлага 4.2 сая, хувь хүмүүсээс авах авлага 3.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Тайлант онд шинээр авлага үүсгэхгүй байх,

Өмнөх оны авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

1. Төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, Холбогдох хууль эрх зүйн акт зөрчигдөх.
2. Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдэл хангагдахгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар өгсөн зөвлөмжтэй танилцсан болно.

4.3 Орлогын талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд хэвлэх цехэд УИХ-ын байнгын хороод болон УИХ-ын гишүүдийн захиалгын дагуу үйлдвэрлэн, батлагдсан төсвөөс нь бэлэн бусаар суутган тооцсон 52.8 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүний орлогыг үйл ажиллагааны орлого дансанд бүртгэж, тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэснийг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

1. Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх.
2. Борлуулалтын орлого буруу илэрхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний бэлнээр болон суутган, дараа тооцоогоор борлуулсан борлуулалтын орлогыг бууруулах бичилт хийлгүйгээр үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар өгсөн зөвлөмжтэй танилцсан болно.

4.4 Зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

а) Тайлант онд Хэвлэх цехийн үйлдвэрлэсэн 17.9 сая төгрөгийн өртөгтэй “Төрийн мэдээлэл” сэтгүүлийг Төрийн тусгай шуудан, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц зэрэг байгууллагуудад үнэ төлбөргүй олгож, үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний нэгжийн өртөг өсөх, цех алдагдал хүлээх нөхцлийг бүрдүүлсэн,

б) Тайлант онд батлагдсан төсвийг нийт дүнгээрээ хэмнэсэн боловч зарим нэр төрлийн зардлыг 5.4-35.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,

в) Урсгал зардлын батлагдсан төсвөөс 80.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж,", 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

1. Төсвийн үргүй зардал гарах, Холбогдох хууль эрх зүйн актууд зөрчигдөх,
2. Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн мэдээлэл сэтгүүлийг бусад байгууллагуудад бага үнээр нийлүүлэх шаардлагатай бол өртгөөр нь тооцон олгож, хэвлэх цехийг алдагдалгүй ажиллуулах,

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийг хэтрүүлэхгүй байх зөвлөмжийг өгөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газар ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар өгсөн зөвлөмжтэй танилцсан болно.

5 АУДИТ ХИЙГДСЭН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**5.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	292,983.4	520,879.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,557.2
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
АВЛАГА	5,341.8	29,593.7
УРЬДЧИЛГАА	-	-
БАРАА МАТЕРИАЛ	287,641.5	489,729.0
НӨӨЦИЙН БАРАА	-	-
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,860,914.3	6,095,866.9
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,860,914.3	6,095,866.9
Газар	-	-
Биет хөрөнгө	5,759,003.9	6,032,623.0
Биет бус хөрөнгө	101,910.4	63,243.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,153,897.6	6,616,746.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,641.2	3,630.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,641.2	3,630.7
Өглөг	1,171.2	3,630.7
Урьдчилж орсон орлого	6,470.0	-
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,146,256.4	6,613,116.1
Засгийн газрын хувь оролцоо	6,146,256.4	6,613,116.1
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,560,849.8	3,560,849.8
Хуримтлагдсан үр дүн	2,585,406.7	3,052,266.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,153,897.6	6,616,746.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	20,114,522.7	34,705,800.9
ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,523,764.5	2,877,525.0
Нийтлэг татварын бус орлого	2,483,075.2	2,741,175.9
Хөрөнгийн орлого	-	-
Тусламжийн орлого	40,689.3	136,349.1
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,590,758.2	31,828,275.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	20,926,304.8	33,921,735.2
УРСГАЛ ЗАРДАЛ	20,926,304.8	33,921,735.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,865,784.7	31,366,088.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,483,131.2	8,479,612.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	859,037.7	910,477.7
Хангамж, бараа материалын зардал	1,200,360.1	1,180,133.2
Нормативт зардал	-	-
Эд хогшил, урсгал засварын зардал	140,297.4	67,698.7
Томилолт, зочны зардал	3,813,507.0	1,536,786.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,257,586.4	1,595,224.6
Бараа үйлчилгээний бусад зардал	3,111,864.9	17,596,155.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,060,520.1	2,555,646.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(811,782.1)	784,065.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1.5	180,857.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(811,783.6)	603,208.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,958,040.1	-	6,958,040.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	21,659.0	-	21,659.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,979,699.1	-	6,979,699.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(21,659.0)	-	(21,659.0)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	(811,783.6)	-	(811,783.6)
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,146,256.4	-	6,146,256.4
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,146,256.4	-	6,146,256.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,146,256.4	-	6,146,256.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(136,349.1)	-	(136,349.1)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	603,208.8	-	603,208.8
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,613,116.1	-	6,613,116.1

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	20,060,614.8	34,405,903.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,451,179.4	2,516,310.6
Нийтлэг татварын бус орлого	21,244.4	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0
Тусламжийн орлого	2,429,935.0	2,516,310.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,609,435.4	31,889,593.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,341,169.2	32,593,396.5
УРСГАЛ ЗАРДАЛ	19,341,169.2	32,593,396.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,284,013.5	30,040,049.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,483,131.2	8,485,507.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	859,037.7	908,503.4
Хангамж, бараа материалын зардал	1,253,854.4	1,169,333.9
Эд хогшил, урсгал засварын зардал	139,641.2	76,220.1
Томилолт, зочны зардал	3,631,867.3	1,735,405.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,811,577.5	1,303,389.4
Бараа үйлчилгээний бусад зардал	2,104,904.2	16,361,690.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,057,155.8	2,553,347.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	719,445.5	1,812,507.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	726,751.9	1,810,950.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	726,751.9	1,810,950.1
Дотоод эх үүсвэрээр	726,751.9	1,810,950.1
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-726,751.9	-1,661,933.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-7,306.4	1,557.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,306.4	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,557.2



5.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,088,911.6	31,862,818.0	2,226,093.6	93.5
УРСГАЛ ЗАРДАЛ	32,400,911.6	30,200,884.6	2,200,027.0	93.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,608,971.9	28,947,168.9	1,661,803.0	94.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,791,257.3	8,485,507.1	305,750.2	96.5
Үндсэн цалин	6,525,518.0	6,399,875.5	125,642.5	98.1
Нэмэгдэл	1,866,778.1	1,740,155.6	126,622.5	93.2
Унаа хоолны хөнгөлөлт	398,961.2	345,476.0	53,485.2	86.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	949,878.3	908,503.4	41,374.9	95.6
Хангамж, бараа материалын зардал	1,386,206.3	1,210,465.4	175,740.9	87.3
Бичиг хэрэг	164,991.0	170,355.9	(5,364.9)	103.3
Тээвэр, шатахуун	692,398.6	617,553.0	74,845.6	89.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,349.9	188,003.4	62,346.5	75.1
Ном, хэвлэл	205,000.0	160,770.9	44,229.1	78.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,466.8	73,782.2	(315.4)	100.4
Эд хогшил, урсгал засварын зардал	139,423.0	138,437.5	985.5	99.3
Багаж, техник, хэрэгсэл	8,500.0	11,926.2	(3,426.2)	140.3
Тавилга	15,000.0	50,893.5	(35,893.5)	39.3
Урсгал засвар	115,923.0	75,617.9	40,305.1	65.2
Томилолт, зочны зардал	1,830,716.8	1,735,405.2	95,311.6	94.8
Гадаад албан томилолт	849,000.0	847,429.0	1,571.0	99.8
Дотоод албан томилолт	759,879.6	689,405.3	70,474.3	90.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	221,837.2	198,570.9	23,266.3	89.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,363,131.6	1,304,889.4	58,242.2	95.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,331,131.6	1,281,262.4	49,869.2	96.2
Даатгалын үйлчилгээ	30,000.0	21,627.0	8,373.0	72.1
Тээврийн хэрэгслийн татвар	2,000.0	2,000.0	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	16,148,358.6	15,163,960.8	984,397.8	93.9
Бараа үйлчилгээний бусад зардал	14,115,918.8	13,493,535.1	622,383.7	95.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,032,439.8	1,670,425.7	362,014.1	82.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,791,939.7	1,253,715.7	538,224.0	69.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	43,053.1	32,278.9	10,774.2	74.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	43,053.1	32,278.9	10,774.2	74.9
Бусад урсгал шилжүүлэг	1,748,886.6	1,221,436.8	527,449.8	69.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	119,500.0	48,279.3	71,220.7	40.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	450,000.0	323,782.3	126,217.7	71.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	371,001.4	121,679.6	249,321.8	32.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	808,385.2	27,695.5	80,689.7	9.0

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,688,000.0	1,661,933.4	26,066.6	0.0
Тоног төхөөрөмж	1,688,000.0	1,661,933.4	26,066.6	98.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,088,911.6	31,864,375.2	2,224,536.4	93.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,371,136.6	29,348,064.6	2,023,072.0	93.6
Улсын төсвөөс санхүүжих	31,371,136.6	29,348,064.6	2,023,072.0	93.6
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	2,717,775.0	2,516,310.6	201,464.4	92.6
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	2,717,775.0	2,516,310.6	201,464.4	92.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,557.2	(1,557.2)	0.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	100.0
Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
Төсвөөс гадуур байгууллага	1.0	1.0	-	0.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	626.0	600.0	26.0	97.1
Удирдах ажилтан	93.0	81.0	12.0	78.5
Гүйцэтгэх ажилтан	507.0	491.0	16.0	100.0
Үйлчлэх ажилтан	26.0	28.0	(2.0)	107.7
Гүйцэтгэх ажилтан /төсөл/	4.0	4.0	-	100.0